

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
1.1	Эцэг/эхийн нэр: Чойжил Нэр: Энхбаяр
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/ Тийм Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/.Үгүй
1.4	Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; Санхүү-Эдийн засагч мэргжилтэй. Эдийн засгийн ухааны докторын зэрэгтэй. МУИС-ийн профессор цолтой. -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; Улс төрийн намын гишүүнээр элсэж байгаагүй, ямар нэгэн улс төрийн үйл ажиллагаа явуулж байгаагүй -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; Хугацаа хэтэрсэн өргүй -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; Ёс зүйн зарчмыг баримтлан ажилладаг салбартаа нэр хүндтэй -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ. <ul style="list-style-type: none">албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно); Олон улсын мэргэжлийн Web of Science-д бүртгэлтэй Q1ранкийн сэтгүүлд 3 өгүүлэл хэвлүүлсэний 1 өгүүлэлд 1-р зохиогчоор ажилласан. Татварын албанд 8 жил, Татварын боловсрол олгох чиглэлээр 21 жил ажиллаж байна.эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.

	<p>Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр нийт 13 ном, сурах бичиг, гарын авлага бичиж туурвисан ба 41 эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэний 11-ийг нь олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн. Мөн энэ чиглэлээр 29 илтгэл олон улсын болон үндэсний хэмжээний ЭШХуралд хэлэлцүүлж, 18 төсөлд судлаачаар оролцож, төсөл удирдаж ажилласан байна. Бүтээлийн жагсаалтыг хавсаргав.</p>
<p>1.5</p>	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; <ol style="list-style-type: none"> 1. МУИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн захирлаар ажиллаж байна. 2023.12.01, 2023.01.18 МУИС-ийн санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж 2023 онд 200,0 гаруй сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон. 2. МУИС-ийн төсвийн 30 нэгжийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах ажлыг удирдан Захиргааны зөвлөл, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан 2018 оноос оноос хойш төлбөр нэмээгүй, боловч цалинг 2 удаа нэмсэний улмаас 2020 оноос алдагдалтай ажиллаж эхэлсэн төсвийн алдагдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан 2022-12 сар 3.Төрийн өмчит их сургуулиудын статус тодорхойгүй, нягтлан бодох бүртгэлийн аль стандартыг мөрдөх нь маргаантай байсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2023 оны 05 сард төрийн өмчийн 6 их сургууль, БШУЯ, СЯ, ТӨБЗГ, YAГ, УБЕГ зэрэг байгууллагын холбогдох хүмүүсийг оролцуулсан хэлэлцүүлгийг санаачлан зохион байгуулсан. Үүний үр дүнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13-р зүйлийн 4-т төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол гэсэн заалт нэмэгдсэн /Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./ 4. Бизнесийн сургуулийн захирлаар ажилласан – 2017.04.21-2023.01.18 – Сургуулийн үйл ажиллагааг бүхэлд нь удирдан зохион байгуулж, санхүүг үр ашигтай удирдан 6,0 тэрбум төгрөгийн хуримтлалыг 5 жил гаруй хугацаанд бий болгож, МУИС хөрөнгө оруулалт хийх эх үүсвэрийг нэмэгдүүлсэн. 5. Бизнесийн удирдлагын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргаар ажиллаж байна 2017 оноос – Энэ хугацаанд санхүү, бизнесийн чиглэлийн доктор хамгаалуулах зөвлөлийн хуралдааныг тогтмол удирдаж жил бүр 1-3 залуу эрдэмтнийг төрүүлж байна. 6. Санхүүгийн удирдлага, татварын чиглэлээр нийт 13 ном, сурах бичиг, гарын авлага туурвиж, энэ чиглэлийн онол, практикийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж ирсэн. 7. Нээлттэй нийгэм форумын захиалгаар Монгол улсын 2014 оны төсвийн төсөлд тойм дүгнэлт өгсөн. Төсвийн хэлэлцүүлгийн үеэр тодорхой саналуудыг харгалзаж үзсэн байдаг. 8. Монгол улсад татварын мэргэшсэн зөвлөхийн үйл ажиллагааг шинээр нэвтрүүлэхэд хүчин зүтгэж анхны сургалтыг явуулах багш нарын нэгээр ажиллаж ирсэн ба энэ үйл ажиллагаа өнөөдөр амжилттай бүрэлдэн хөгжиж байна /2004 оноос өнөөг хүртэл/ 9. МУИС-д Татвах хураалт хяналт, Татварын бүртгэл, Санхүүгийн хяналт шалгалт зэрэг хичээлүүдийг олон жил заасан ба хичээлийг онол, практик хослуулж зааснаар оюутнуудын сонирхол эрс дээшилж 2003 онд анх багшаар очиход Татварын мэргэжлээр 7 хүүхэд суралцаж байсан бол 2009 оны хамгийн сүүлийн төгсөлтөөр 29 хүүхэд уг мэргэжлээр төгсөж байв. 10. Баянгол дүүргийн татварын хэлтэст татварын байцаагчаар ажиллаж байсан. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчдөд зөвлөн туслах ажлын арвин туршлага хуримтлуулж, татварын байцаагчийн мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн. Улмаар энэ чиглэлээр улам хөгжих зорилгоор ОХУ-ын ерөнхийлөгчийн тэтгэлэгт аспирантурт суралцаж шалгалт өгч тэнцэн 3 жил суралцаж “Монгол улс дахь татварын шинэчлэл:Онцлог ба хэтийн төлөв” сэдвээр эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2002.03.06
<p>1.6</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.</p>

	<p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. ММНБИ-ийн гишүүн – 2004 оноос 2. ТМЗ нийгэмлэгийн гишүүн – 2005 оноос, 2007-2009 УЗ-ийн гишүүн 3. ММҮН – 2007 оноос гишүүн 4. МҮЦАЭХ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүн – 2018-2022 5. СЗХ – Үнэт цаасны бодлогын зөвлөлийн гишүүн – 2022 оноос одоог хүртэл 6. Сэндбоксын зөвлөлийн гишүүн – 2021 оноос одоог хүртэл
1.7	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>Бүтээлийн жагсаалтаас үзнэ үү.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>https://forum.mn/product/152357</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>2018.12.03 – Монголын энтрепренерийн нэгдсэн чуулган - Шинжлэх ухааны салбаруудын хамтын ажиллагаа, Бизнесийн сургуулийн гүйцэтгэх үүрэг илтгэл</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Эдийн засгийн төлөв байдлын талаар Блүүмберг ТВ-д жил бүр ярилцлага өгдөг. Зарим зургийг хавсаргав. Ярилцлагын линк олдохгүй байна.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>
1.8	<p>Эрүүгийн хариуцлага</p> <p>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ - Үгүй</p> <p>.....</p>
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар</p> <p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх - Үгүй</p> <p>.....</p>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p>
2.1	<p>Миний бие санхүү-эдийн засагчийн мэргэжил эзэмшиж, ажлын гараагаа татварын албанд ажиллаж эхэлсэн бөгөөд 32 дахь жилдээ ажиллаж байна.</p> <p>Сүүлийн 20 гаруй жил төсөв, татвар, бизнесийн болон зан төлөвийн санхүүгийн чиглэлээр бие даасан, хараат бус, шинжлэх ухааны үндэслэлтэй хараат бус судалгааг хийн, олон нийтэд таниулах, хэвлэн нийтлүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэж ирлээ.</p> <p>Монгол улсын төсвийн эх үүсвэрийг голлон бүрдүүлэгч бизнесийн орчныг сайтар таньж ойлгосон, онолын төдийгүй практик мэдлэгтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, өндөр ёс суртахуунтай байж гэмээнэ төсвийн бодлого төлөвлөлтийг өргөн хүрээнд харж, үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой гэж би хувьдаа үздэг.</p>

Энэ ч үүднээс Монгол улсын төсвийн төслийг хэлэлцэх үеэр өөрийн санал бодлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр идэвхтэй илэрхийлдэг байсан боловч энэ нь төдийлөн бодлого болосруулагчдын түвшинд хүрдэггүй байв.

Тухайлбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдахад “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний **хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх**” гэсэн заалт орсон боловч сүүлийн 2 жилийг эс тооцвол энэ хувь өндөр явж, өнөөг хүртэл энэ заалт хэрэгжихгүй байгаад мэргэжлийн хүний хувьд ихэд эмзэглэж явдаг. Төсвийн бодлого оновчтой, төсвийн төлөвлөлт бодитой хийгдэж явбал энэ заалт хэрэгжих бүрэн боломжтой юм. Түүнчлэн нөхөн сэргээгдэхгүй, шавхагдах нөөц баялгаа идэвхтэй ашиглаж байгаа энэ үед ирээдүйдээ үлдээх өв сангаа арвижуулж, түүний менежментийг сайн хийх асуудал ч чухал байна.

30 гаруй жилийн хугацаанд өөрийн сурч мэдсэн, олж эзэмшсэн мэдлэг ур чадвараа улс орныхоо хөгжилд зориулах чин эрмэлзлэлтэй хөдөлмөрлөж ирсэн бөгөөд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд ажиллах нь илүү өргөн цар хүрээтэйгээр улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах томоохон боломж, нөгөө талаас иргэний үүргээ биелүүлэх сорилт байх болов уу гэж бодож байна.

Хэрэв Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр сонгогдвол дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсөв болон түүний тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах; Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хүсэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах ажилд идэвхтэй оролцох;
2. Төсвийн бодлогын хэрэгжилтийн сүүлийн 5 жилийн судалгааг бие даасан, хараат бусаар мэргэжлийн түвшинд хийн дүгнэлт гаргаж, уг бодлогыг боловсронгуй болгох чиглэлд зөвлөмж өгөх;
3. Түүнчлэн төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр цаг үеийн шинжтэй судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гарган Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;
4. Төсөв, санхүүгийн холбогдолтой шийдвэрийн нөлөөллийг олон нийтэд таниулах ажилд манлайлан оролцож олон нийтийг төсвийн талаархи мэдээллээр хангаж, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллахад хувь нэмрээ оруулна.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Чойжил

Өөрийн нэр: Энхбаяр

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2023.12.07

--- оОо ---